

**МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАРИЛЦАА БА
ЖАЛХАНЗ ХУТАГТ ДАМДИНБАЗАР
(1918-1920)**

Л.Нямсүрэн

Ховд Их Сургууль. Нийгмийн ухааны тэнхим

Өгүүллийн товч утга: Дундад Иргэн Улсаас Богд хаант Монгол Улсын өөртөө эзэрхэн захирах эрхийг устгаж, тусгаар тогтнолыг цуцалсан түүхэн зурвас үеийн [1918-1920] Монгол-Америкийн улс төр, эдийн засгийн харилцаанд холбогдох судалгаа шинжилгээнд хамрагдаагүй түүхэн баримтуудыг эргэлтэнд оруулах, түүнийг нарийвчлан судлах асуудал чухлаар тавигдаж байна. Иймээс эл зурвас үед Монгол-Америкийн засгийн газрын төлөөлөгчдийн хооронд улс төр, худалдаа арилжааны харилцаа тогтоох асуудлаар Орос, Хятадын Засгийн газарт мэдэгдэлгүйгээр нууцаар явагдсан анхны албан ба албан бус уулзалт, хэлэлцээрүүд, тэдгээрт АНУ, Монголын Засгийн газрын баримталж байсан байр суурь, түүнд Самади багш, Номун хан, гүжир хамбо Жалханз хутагт Дамдинбазар хэрхэн оролцож, ямар үүрэг гүйцэтгэж байсныг судалгааны ажлын хүрээнд тодруулахыг оролдсон болно.

Түлхүүр үг: Монгол улсын өөртөө эзэрхэн захирах эрх, тусгаар тогтнол, үндэсний эрх ашиг, Монгол-Америкийн улс төр, худалдааны харилцаа

XIX зууны II хагасаас Манж чин улс дэлхийн хүчирхэг гүрнүүдийн хагас колони орон болон хувирчээ. Энэ үед Манж чин улсын эрхшээлд байсан Монгол оронд Англи, Герман, Франц, АНУ зэрэг орнуудын капитал Хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдээр дамжин орж ирэх болов. Улмаар АНУ-ын элчин, консулын газар Бээжин, Хаалганд байгуулагдсан нь Монголчуудын хувьд тэдэнтэй харилцаа холбоо тогтоох анхны гүүр болсон юм. Америкчууд ч гэсэн Монгол орны зах зээлийг ихэд сонирхож Монголд болж буй үйл явдлыг ажиглан түүнд нөлөөлөх боломжийг эрж хайх болжээ. Тэд Америкийн Нэгдсэн Улсын төрийн нарийн бичгийн дарга Джон Хэйгийн 1899 онд тунхагласан “Нээлттэй хаалганы” зарчмийн дагуу Монгол дахь Хаант Орос, Япон, Английн нөлөөг ховх цохин хаяж өөрсдийн нөлөөний хүрээг тогтоох өргөжүүлэхэд анхаарлаа хандуулж байв.

Гэвч дэлхий ертөнцийн эсрэг хоёр талд нэг нэгнээс хамгийн алс оршигч огт өөр түүх, хэл, соёл, зан заншил бүхий Монгол улс, АНУ-ын хооронд харилцаа холбоо тогтоож, хамтын үйл ажиллагаа явуулах нь ихээхэн ээдрээтэй үйл явц байлаа.

1918-1919 оны үест Монгол улсын гадаад дотоод байдал ихэд хүндэрч, өөртөө засах эрх алдагдах аюул нүүрлэмэгц Богд тэргүүтэй засгийн газар дан ганц өөрсдийн хүчээр бүхнийг шийдвэрлэхэд хүчин мөхөсдөх учраас гуравдагч орноос дэмжлэг туслалцаа авахыг оролдон янз бүрийн арга сүвэгчилж байв.

1918 онд Бээжингээр дамжин Их хүрээнд ирсэн Америкийн хоёр худалдаачин Жалханз хутагт Дамдинбазар, ерөнхий сайд Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн хамт нөхөрсөгөөр хүлээн авч уулзан Орос, Хятад улс Монголын тусгаар тогтнолыг хүч түрэмгийлэн устгасан хууль бус үйл ажиллагааг [1915 оны 3 улсын гэрээ Л.Н] шүүмжлэн улс орныхоо байдлыг ярилцахын зэрэгцээ Монгол улс Америкчуудтай найрамдалт харилцаа тогтоох их хүсэлтэй бөгөөд Америкийн пүүсүүд төлөөлөгчдөө илгээнэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэхийн хамт АНУ-аас Их хүрээнд консулын газар нээхийг маш их хүсэж байгаагаа өгүүлжээ.

Тэдгээр худалдаачид энэ уулзалтын тухай Бээжин дэх АНУ-ын худалдааны атташе А.В Ферринээр дамжуулан АНУ-д анх мэдэгджээ. Тэрхүү мэдэгдэлд "...Монголчууд арьсны үзлийн хувьд Америкчуудад нөхөрсөг ханддаг бөгөөд Орос бас Японоос эмээдэг болох нь илэрхий. Гэвч тэд Америкаас дэндүү хол тул өөрсдийг нь хэн ч сонирхдоггүй байх гэж үздэг. Хэрвээ Америк улс Өргөө хотод консултай болвол улс төр, худалдаа арилжааны хувьд ихээхэн нөлөө үзүүлэх бөгөөд энэ сайхан орны хөгжилд тустай байх болно"[Mongolia Survey...1999, тал 48-49] гэжээ.

А.В Ферриний АНУ-д илгээсэн мэдээ хоёр орны харилцааны түүхэнд маш их ач холбогдолтой болов. Учир нь Хятад дахь Америкийн албаны хүн АНУ-ын засгийн газарт Монголын нутагт албан байгууллага нээх талаар анх удаагаа улс төрийн үзэл бодлоо илэрхийлжээ. Ингэж холын Америк орон Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтох анхны эхлэл тавигджээ.

Ийнхүү Жалханз хутагт, ерөнхий сайд Намнансүрэн нар Америк улсыг түшиглэн тэдний дэмжлэгийг авч алдагдсан тусгаар тогтнолоо дахин сэргээх найдлага тавьж, дипломат харилцаа тогтоох оролдлого хийсэн нь зохих үр дүнд хүрсэн байна.

Хятад дахь АНУ-ын элчин сайд Павел Рейнш 1919 оны 2 дугаар сард төрийн хэлтсээсээ Монгол улс бүс нутгийн ирээдүйн худалдаа арилжаанд чухал үүрэг гүйцэтгэх тул Хаалган юм уу, Өргөөд консулын газар нээх санал тавьжээ. Түүний захианд улс төрийн байдлыг дурдаагүй боловч Жулиан Арнольддын [худалдааны атташе] бичсэн улс төрийн илтгэлийг хавсаргажээ. Арнольд түүндээ Өргөөд консулын газрыг байгуулах нь АНУ-ын худалдааны эрх ашигт тустай бөгөөд бусад сөрөг гадаад нөлөөнөөс сэргийлнэ гэжээ. Тэрээр Монголчууд Хаалган юм уу, Өргөөд АНУ-ын төлөөлөгч суулгах саналыг дэмжиж байна гэсэн санааг Ф.Ларсонтой хийсэн уулзалтаас ойлгосноо өгүүлжээ. 1919 оны үед Хаалганд 5, Өргөөд 2 АНУ-ын пүүс

байгуулагджээ. Арнольдын мэдээлснээр Монголын экспортын худалдаа 15 сая доллар байв. П.Рейншийн захидал, Арнольдын илтгэлийг Вашингтонд төрийн хэлтсийн хүрээнд хэлэлцэж эхэлжээ. ...Төрийн дотоод хэлтсийн захидалд тэмдэглэхдээ АНУ-ын засгийн газар нь Монголын тал нутагт консулын газар нээх үндсэн зорилгоо худалдааных биш харин Японы эзэрхийлэл, Большевикуудын түрэмгийлэлийг хаах гэсэн улс төрийн шалтгаантай гэжээ.[Mongolia Survey...1999, тал 48-49]

Гэвч 1919 оны эхээр Консулын газар нээх асуудал удааширч, дэмжлэг ч хангалттай бус хэвээр байлаа. Энэ үед Хятад сайд Чен И Монголын автономит засгийг устгах ажиллагаагаа улам идэвхижүүлэхдээ Монголын төрийн зүтгэлтнүүд болон нөлөө бүхий ноёд, лам нарын дотоод зөрчил, тэмцлийг ашигласан байна. 1919 оны хавар Сайн ноён хан Намнансүрэн нас барж, түүний оронд Улсын ерөнхий сайдын тушаалд шанзав Бадамдорж тохоогдсоны улмаас улс үндсээ гэх дэвшилт үзэлтэй, бас хятадын талыг баримтлагч ноёд лам нарын хоорондын тэмцэл улам хурцдав.

Учир иймд Жалханз хутагт Дамдинбазар сэдэвлэн санаа сэтгэл нийлсэн нөхдийн хамт урьд холбоо тогтоосон АНУ-д ихээхэн найдлага тавьж, түүнээс тусламж дэмжлэг олохыг оролдож байлаа. Тэрбээр хуучин танил швед гаралтай Америкийн худалдаачин Ф.А Ларсонтой 1919 оны намар уулзаж ярилцахад тэрбээр "АНУ бол баян чинээлэг, бага буурай улсыг тэтгэх дуртай, хэрэв Америк үгээ хэлбэл Хятад төдийлөн хандаж зүрхлэхгүй" [Н.Ишжамц.УБ.,1999 тал 14] хэмээн өөрөө машинаа хөдөлгөж, Жалханз хутагттай цуг Бээжинд очиж, Америкийн ерөнхий ахлах консултай уулзуулж өгөхөө амласан байна.

Монголын автономийг устгах явдал хараахан хүчин төгөлдөр болоогүй байх үед ...Богд хаанаас ...урьд Бээжинд зарагдсан шадар сайд дайчин жонон ван Цогбадрахад Их жунтан Ли Юуван Хуангаас Гадаад монголын газар суугаа хятад түшмэл хэрэв Богд хааны таалалд үл нийлэх үгүй хэргийг явуулваас Богдоос түшмэл зарах буюу захидлаар Их жунтанд нэвтрүүлж шударга түвшин болгон шийтгүүлж болмой хэмээсэн захиа бүхийг баримт болгож хятад элчин Чен И Монголын эрх баригчид лугаа хуйвалдан засгийн эрхийг устгахаар сэдэвлэн бүхий хэрэгт олон монголчууд дурлах үгүй тул уг хэвээр тогтнуулж болмой хэмээн Их Жунтанд илгээх нууц захидал бичүүлж, мөнхүү дайчин вангийн хошууны гүн Гомбыг Бээжинд зарж

явуулсан хэрд гүн Гомбоос уг хэргийг нэвтрүүлж чадах үгүй тулгамдаж ихээхэн лам ноёдын нэгийг ирүүлтүгэй хэмээн цахилгаанаар хойш мэдэгдсэн тухайд Богд хаанаас Жалханз хутагт Дамдинбазарыг томилон илгээсэн [Н.Магсаржав.УБ.,1994 тал 156] ажээ. Энэ нь Жалханз хутагт Дамдинбазарын гадаад улсад хийсэн анхны нь дипломат айлчлал байв.

Энэ тухай Дилав хутагт дуртгалдаа тэмдэглэхдээ "...Жалханз гэгээн тэргүүтэй гэгээд, ноёд түшмэл нар нэгэн анги бүлгэм сэмээр хуралдан зөвлөж, гагцхүү Америк улс баян хүчирхэг, буурайг тэтгэх дуртай хэмээн алдаршсаны дээр Америк улсаас үг гарваас Хятадын засгийн газар эрхбиш гээхгүй хэмээх тул Америк улсаас тусламж эрэхээр тогтож, Богдод айлтгасанд Богдоос ихэд зөвшөөрч мөн Жалханз гэгээнийг төлөөлөгчид томилж, Да жунтанд Богдын хувиас тал бэлэг хүргэх нэрийдлээр Бээжинд очиж, Хятад засгийн газар монголчуудыг амар тайван байлгах явдлыг илтгэх ба дашрамд Мэй улсын их түшмэл сайдууд лугаа учирч тусламж гуйхад Америк улсын Андерсен Мейер хэмээх худалдааны гэрийн наймааны хүн Ларсон лугаа хэлцэж, түүний мухар тэргээр өвлийн эхэн сарын шинийн 3-нд сэмээр мордов гэжээ.

Гэтэл Чен И-гийн 1919 оны 10 дугаар сарын 22-нд явуулсан цахилгаан, мөн сарын 28-ны мэдээнд ...Жалханзаас түрүүлэн таван лам гарчээ. Тэд 10 дугаар сарын 19-нд Бээжин орохоор Хүрээнээс гарчээ. Тэдэнд тайж язгууртан нар нэн дургуй байсан ажээ. ...Богд хааныг дургуйцсээр байтал Жалханз 19 онд Бээжин орохоор Их Хүрээнээс явсан. Ларсен нэн зальхай хүн байсан хэмээн [Ариун сэтгэл авралын үндэс.УБ.,2000 тал 101] дурдсан байдаг агаад үүнийг нотлох архивын баримт, сурвалж бичгийн мэдээ үгүй юм.

Ийнхүү 1919 онд Жалханз хутагт дагуулуудын хамт Хятадын нийслэл Бээжин рүү нэгд, Монголын автономийг устгахгүй байхыг гуйн хэлэлцээр хийх хоёрт, хэлэлцээр эс бүтвээс АНУ-тай холбоо тогтоож, тусламж дэмжлэг авах зорилготой морджээ. Тэднийг аян замдаа явж байх үед Хятадын засгийн газар Сюй Шүжанаар удирдуулсан цэргийн хүчийг Монголд түлхэн оруулжээ.

Жалханз гэгээн Сюй шүжантай ойр зөрөлдсөн боловч уулзаагүй аж. Жалханз хутагтыг Хаалганд ирэхэд Цахарын цэргийн захирагч Тен овогт угтан, улмаар Засгийн яаманд мэдэгдсэн тул Гадаад яам болон Монгол-Түвдийн хэрэг эрхлэх хорооноос тусгай түшмэл томилон угтуулж, 1919 оны 11 дүгээр сарын 1-нд Бээжинд ирэхэд тэдгээр яамдаас хүлээн авчээ. Хятадын засгийн газар Монголоос ирсэн

төлөөлөгчдийг сэжиглэн монгол хэл сайн мэдэх хятад иргэн болоод хятадын талыг баримтлагч монголчуудаар тандуулан туршуулсан хүнд нөхцөлд Жалханз хутагт Дамдинбазар ажил үүргээ гүйцэтгэж эхэлсэн байна.

Тэрбээр 1911 оны 11дүгээр сарын 10-нд Хятад улсын ерөнхийлөгч болон холбогдох чухал албаны хүмүүстэй уулзан Богд хаанаас Да жунтанд өргөн илгээсэн захидлыг гардуулжээ. Энэхүү захидал бичигт "Автономийг устгах хэмээснийг олон монгол лам, хар албат нар сонсож ихэд түрхрэн шүүмжлэлдмүй. Монголын сайдууд өөрсдөө санал гаргасан нь бус гагцхүү сайд Чен И-гээс умард хязгаарын байдал ариун үгүйд шалтаг түлхэж, автономийг устгахаар ам сургаж, хүчлэн дагуулах үгний сэдэв гаргаж шаардсаны учир болой"[Богд Жибзундамба хутагтаас Монголын автономит эрхийг хэвээр үлдээхийг хүсч Дундад иргэн улсын Да жунтанд илгээсэн бичгийн хуулбар] хэмээн учир шалтгаанаа нарийн тоочин өгүүлсэн буй.

Жалханз хутагт Дамдинбазар Монголын автономийн асуудлаар сар гаруй хэлэлцэхэд Да жунтан ...энэ хэргийг яарах явдал үгүй хутагтын тааллаар автономит засгийн эрхийг хэвээр хадгалж болмой" хэмээх тохиролцоонд хүрсэн бөгөөд улмаар Монголчуудын үнэн хүсэл юуг илтгэсэн чуулган хошуудын бүрэн тамгатай бичгийг авч Монголоос арваас доош тооны төлөөлөгч нарыг дахин Бээжинд очуулан хэлэлцэж тогтоохоор болсон төдийгүй монголчуудын хүсэлд нийлүүлэн сэтгэлийг амар болгох зүйлийг зохистойгоор шийдэж, хэрхэвч гомдож гаслахад хүргэхгүй [Н.Магсаржав.УБ.,1994 тал156, Л.Дэндэв.УБ.,1934 тал 174] хэмээсэн хариу өгчээ. Тийнхүү Жалханз хутагтыг Монголын автономит эрхийн асуудлаар Бээжинд сар гаруй суухад Хятадын засгийн газрын албаны хүмүүс Монголд ийм ухаантай хүмүүс байсан аж хэмээлцэн их л гайхсан гэдэг.

Хятадын удирдлага монголчуудтай харилцаа хурцадсаныг өмнөх Манж чин улсын үйл ажиллагаатай холбож, харин эдүгээ үед нэгэн улсын хүрээнд байх ёстой мэтээр асуудлыг авч ярилцахад Жалханз гэгээн хоёр улсын ард түмний байдал, хоорондын харилцааг хүндрүүлж буй нь цэргийнхний дарангуй үйл ажиллагаа, Хятадын ерөнхийлөгч, засаг төрөөс огцом нэг талыг барьсан шийдвэр гаргаж байгаатай улбаатайг аядуу тайвнаар илэрхийлэн, шашны айлтгалын өнгө аясаар тэдэнд ойлгуулан цаг хугацаа хожин шууд шийдвэр гаргуулахаас ямар нэгэн байдлаар хойшлуулсан нь гэгээнтний улс төрийн нарийн бодлогын нэгэн илэрхийлэл [Хоёр их хутагт.УБ.,1994 тал 26] байжээ.

Жалханз хутагт Дамдинбазарыг Бээжинд Монголын автономийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх хугацаанд Сюй шүжан Их хүрээнд ирмэгц өөрийгөө баруун хойд хязгаарын хэргийг бодуулан шийтгэх дарга хэмээн өргөмжилж, цэргийн дэглэм тогтоон улмаар Чен И-г огцруулан, Монголын автономийг устгах хэргийг цэргийн захиргаа бие даан шийдэх болсныг зарлаж, монголчуудад автономии сайн дураараа устгах тухай бичгийг даруй гаргаж өгөх шаардлагыг хүчээр тавьжээ. Монголчууд аргагүй хүчинд автан 1919 оны 11 дүгээр сарын 15-нд өөртөөн засах эрхээ сайн дураараа халах өргөдөл гаргаж, мөн сарын 17-нд Сюй шүжанд өргөн гардуулжээ. Тэрээр уг бичгийг Хятадын засгийн газарт явуулсан бөгөөд Хятадын ерөнхийлөгч 11-р сарын 22-нд Гадаад Монголын автономийг устгасан тухай зарлиг гаргажээ. Сюй шүжан монгол цэргүүдийн зэвсгийг хураан тарааж, Хаант монгол улсын таван яамны тамга хэргийг хүлээн авч, Богд Жибзундамбыг Хятадын ерөнхийлөгчийн хөрөгт мөргүүлэх ёслолыг үйлджээ.

Хятадын эрх баригчид ийнхүү Монголын тусгаар тогтнолыг устгах талаар 1915 онд хийсэн анхны алхмаа бататган 1919 онд Монголын автономит эрхийг зэвсгийн хүчээр устгаж, Монголыг Хятадад хавсарган нэгтгэж, дотоод муж болгох зорилгоо хэрэгжүүлжээ. [М.Ариунсайхан.УБ.,1990 тал 47]

Их хүрээнээс “Гадаад Монгол өөрөө гуйн өргөж, автономит засгийг устган, Дундад иргэн улсад нэгтгэн захируулав” гэсэн цахилгаан мэдээ Бээжингийн Засгийн газарт ирснийг тодорхой мэдээд Жалханз хутагт ихэд гутарсан боловч хоёр дахь боломжоо ашиглахаар шийджээ. Тэрээр Бээжин дэх АНУ-ын хэрэг хамаарагч Чарлез Д.Теннитэй 1919 оны 11 сарын дундуур нууцаар уулзсан нь Вашингтоны Монголын талаарх бодлогыг өөрчлөхөд хүргэсэн гол хүчин зүйл болжээ. Энэ нь хоёр орны төлөөлөгчдийн анхны албан ёсны уулзалт байсан юм. Орчуулагч нь Франц Ларсон байв. Ер нь Ф.Ларсон Монгол, Америк болон Европчуудын дунд хэлмэрч, жуучийн үүрэг багагүй гүйцэтгэн ажиллаж байжээ.

Тус уулзалт дээр Жалханз хутагт Богдын бичсэн тусгай захидлыг [түүнийг Америкийн дэмжлэгийг хүссэн Богд хааны захиаг авч явсан хэмээн Чэн И 1919 оны 10 дугаар сарын 31-нд илтгэсэн байдаг] Америкийн засгийн газарт гардуулж өгчээ. Тус захидалд Богд хаан Америкчуудаас консулаа илгээж, Өргөөд консулын газар нээхийг хүсээд “Бид Америкийн консултай болж, америк хүмүүстэй арилжаа худалдаа хийхэд

маш их баярлах болно” гээд ...энэ захиаг Орос, Хятадын засгийн газарт урьдчилан мэдэгдэлгүйгээр илгээсэн гэдгээ мэдэгджээ. [Mongolia Survey...1999 тал 50]

Удалгүй Чарлез Д.Тенни Жалханз хутагтад консулын газрыг Хаалганд байрлуулж Өргөөтэй байнга харилцаатай байна гэдгээ амласан бөгөөд энэ нь Вашингтоноос өгсөн заавар зөвлөгөөтэй холбоотой байлаа.

Жалханз хутагт Дамдинбазар АНУ-ын Бээжин дэх албаны хүмүүстэй уулзсан сэдэв мэдэгдсэн тул “...Сюй шужан Бээжинд эгж очоод Жалханз хутагтыг битүүлэг харгалзуулан суулгасан ба Дундад улсын арван хоёр сард Хүрээнээ хойш буцаж ирэхэд Бээжингээс галт тэргээр дагалдуулан гаргаж, Жанчхүүд ирээд дагагсдыг тэнд орхигдуулж, гагцхүү Жалханз хутагтын биеийг өөрсдийн хэрэглэсэн уурын тэрэгт суулгаж, мөнхүү сарын хорин долооны өдөр Хүрээнээ буухад Монгол засгийн газраас угтах ёслолын цайны асар бэлтгэж, Хүрээнд бүхүй олон сайд, лам ноёд өргөнөөр хуралдаж, ёслолыг гүйцэтгэсэн болох ба Жалханзын дагагсад нь хойно өөрсдийн хүчээр хөлслөн тээлгэж ирсэн”[Н.Магсаржав. УБ.,1994 тал 162] байна.

Хүрээнд ирмэгц Жалханз хутагт Дамдинбазар Монголын автономийн талаар Да Жунтан болон Хятад дахь АНУ-ын албаны хүмүүстэй уулзаж ярилцсан бүхий л хэрэг явдал хийгээд үзсэн сонссон бүхнээ Богд Жибзундамба тэргүүтэй ноёд, лам нарт нэгд нэгэнгүй айлтгажээ.

Чингээд Богд Жибзундамба тэргүүтэй нөлөө бүхий ноёд язгууртнууд юуны өмнө Дундад Иргэн Улсын Да жунтаны Жалханз хутагтад өгсөн хариуд үндэслэн Монголын аймаг, олон хошуу, чуулганы Монголын өөртөөн засах эрхийг сэргээх, Богд хаанаа хэвээр байлгахыг хүсэмжилсэн тамгат бичиг яаравчлан бэлтгэхийг ноёд язгууртнуудад тушаахын хамт Бээжин явах төлөөлөгчдийг Жалханз хутагт Дамдинбазараар тэргүүлэн нэрсийг сонгон гаргажээ.

Гэвч Сюй Шүжан тэдгээр төлөөлөгчдийн Бээжин явах цаг хугацааг хойшлуулсаар байв. Нөгөө талаас Хятадын дотоодод үймээн самуунтай байсан нь тэднийг саатахад хүргэжээ.

Энэ үед Хүрээнд байсан лам ноёд автономит засгийн дахин босгоход аль улсын тусламж дэмжлэг олох талаар санал зөрөлдөн маргалдах явдал гарч байсан хэдий ч Бээжинд суугаа Америк, Англи, Японы элчинд тусламжийн бичиг явуулахаар болж, Японоос тусламж олохоор Гүррагчаа гүнг явуулсан ба Америкаас тусламж олох

явдлыг бэйс Лувсанжанцан Хүрээнд байсан өөрийн таних худалдааны төлөөлөгч Ларсенаар дамжуулан гүйцэтгэх болсон авч төдийлэн амжилт олоогүй байна.

Ийнхүү Жалханз хутагтын найдаж байсан АНУ-аас тусламж авах асуудал мөд бүтэх боломжгүй болсон үед түүний үзэл бодолд нилээд хувирал гарч, цагийн байдлыг харгалзан, Их хүрээний нууц бүлгэмийнхний туурга тусгаар улсаа сэргээн тохинуулах зорилго, өөрийнх нь үзэл бодолд нийцэж буйг ухаарч тэдний Орос улсаас тусламж гуйх бичигт Богдын тамга даруулах хэргийг дэмжиж байсан боловч хойд хөршийн дотоодод улс төрийн байдал тогтворгүй, улаан, цагааны хоорондын дайн самуунтай байсан тул түүнийг намжтал хүлээх байр суурийг баримталж байжээ.

Энэ үед АНУ-ын Хятад дахь төлөөлөгчид Хаалганд консулын газраа нээх шийдвэр гаргаснаа мэдэгджээ. Дараа нь 1920 оны 4 дүгээр сард Хятад дахь Америкийн консул Чарлез Эберхард Монголын байдлыг туршин үзэх аялалаар Хүрээнд ирсэн байна. Энэ нь АНУ-ын дипломатч хүн Монголд ач холбогдол өгч албан ажлаар ирсэн анхны тохиолдол байв. Жалханз хутагт Чарлез Д.Теннитэй нууцаар уулзсанаас хойш хэдхэн сарын дараа консул Эберхардт Өргөөд гэнэтхэн ирсэнийг Монголын төрийн эрх мэдэлтнүүд АНУ нь Монголын нөхцөл байдлыг нилээд сонирхож байгаагийн илрэл гэж үзжээ. Түүнтэй Жалханз хутагт Дамдинбазар болон Монголын бусад албаны хүмүүс нууцаар шөнө хоёр удаа уулзжээ.

Энэ тухай Дилав хутагтын дуртгалд “Хаврын дунд сард Мэй улсын түшмэл Ибархард Монголын явдлыг үзэхээр Хүрээнээ ирээд Ларсонгийн хамт Жалханз гэгээнд очиж уулзсанд Бээжинд явах төлөөлөгч нар ба ихээхэн ноёд нар уулзаж тусламж эрэх учраа сэмээр илтгэсэн ба Мэй улсаас тусламж гуйсан Богд хааны тамгатай бичгийг Жалханз гэгээн түүний буудалд очиж тушаан өгөв. Энэ тухай Ларсон хэлмэрчлэв, [Ариун сэтгэл авралын үндэс.УБ.,2000 тал 107-108,167] мөн түүний намтарт ...тэр үест Америк улсын албаны хүн ирж манай монголыг тусалж болох мэт үг хэлсэнд Богд хаанаас Жалханз багшийг түүн лүгээ уулзаж хэлэлц хэмээсэнд багш түүн лүгээ уулзан хэлэлцэхэд тэр мөн туслахаар хэлж бичиг авч явах болсонд нэг шөнө дайчин ван Жалцан, мөн түүний хошууны Түвшин захирагч, Хатанбаатар бид нар нийлж тусламж гуйсан бичиг бичиж бэлгийн хамтаар Жалханз багш биеэр аваачиж өгсөн” [Г.Дүйнхэржав.УБ.,1991 тал 22], тэрчлэн ...уг бичигт Гадаад Монголын автономийг сэргээх үндэслэлийг тодорхойлсон болно[Ариун сэтгэл авралын үндэс.УБ., 2000 тал 167] гэжээ.

Үүнээс үзэхэд Богд Жибзундамбын удирдлага дор Жалханз хутагтын заавар зөвлөмжийн дагуу Дилав хутагт тэргүүтэй хүмүүс Монгол улсын хааны нэрийн өмнөөс АНУ-аас тусламж хүссэн бичгийг боловсруулж найруулсан ажээ.

Тус бичигт Монголын тусгаар эрхийн талаарх Хиагтын гурван улсын гэрээ, Сюй Шүжан Монголын Автономит эрхийг хүчээр устгасан тухай өгүүлээд "...манай Богд хаанаас Да жунтунд баяр бэлэг хүргүүлэх ялдарт танай эрхэм улсад учрыг нэвтрүүлж тус хамгааллыг өргөхүй хүмүн явуулах хэмээсэнд Иргэний яамнаас зүй өргөхүйг цаазлан хорисонд арга буюу боогдож ,...эдүгээ хүртэл хоригдсоор буй тэд нар ямар зүйлийн сайнаар эхлэвч итгэхүй бэрх тул эл учрыг Их улсад мэдэгдэх тэнхрүүлэхүйг хүсэвч нэвтэрч хүрэх зам сүвийг олох үгүй арга мохож мэгдүүрэн бүхүйд Эрхэм улсын өршөөнгүйт Засгийн газраас тусгайлан томилон ирсэнд бид бүгдээр баярлалдаж эл бүхүй үнэн байдал дүрсийг товчхоноор тодорхойлон бичиж, "Их улсын засгийн газар нэвтэргүүлснийг хүрмэгц манай монголчуудыг гүн хамгаалалд багтааж одоогийн харгис хатуу, хүчирхэг этгээдээс нэн хурдан хэрхэн ангижруулж сүр хүчнээр батлан хамгаалж, урьдын ёсоор Автономит засгийг байгуулж, Богд хааныг хэвээр хаанд өргөмжилж элдэв эрх мэдлийг өөрөөн засаж шашин үндэснийг бататгаж газар орныг ариутган тохинуулж аль ч улсаас тэмцэл хямралыг өдөөлж халдан зовоох үгүй болгож, амар цэнгэлд оруулбаас бидний Монголчуудад маш гайхамшигтай хэмээх ч байтугай Их улсад ашиг буй. Иймийн тул их найрамдлын ёсоор гуйсугай"[Campi.Alicia Jean.1988 page 276] хэмээн өгүүлжээ.

Жалханз хутагт болон Монголын албаны хүмүүс АНУ-ын хамгааллыг эрж, Хятадын эрхшээлээс чөлөөлөгдөхийг хүссэнийг сонсоод Эберхардт "ямар нэгэн материаллаг үр дүн хүлээх хэрэггүй" гэдгээ илэн далангүй өгүүлээд АНУ Монголыг дэмжих ямар ч үйл ажиллагаа явуулж чадахгүй нь харамсалтай. Учир нь Хятадтай нөхөрсөг харилцаатай тул хэрэв Монголыг дэмжвээс Хятадын талд найрсаг бус хандсан хэрэг болно гэжээ. Гэсэн хэдий ч Монголчууд Эберхардт гурван баримт бичиг өгсөн байна. Нэг нь "Statement of facts" нэртэй Монголчуудыг Хятадын эрхшээлээс ангижруулахад дэмжих АНУ-ын цэргийн тусламж хүссэн өргөдөл, нөгөө хоёр нь 1915 оны Хиагтын гурван улсын гэрээний хуулбар ба 1919 оны 11 дүгээр сард генерал Ху[Сюй Шүжан] ба Монголчуудын гарын үсэг зурсан Монголын автономит төрийг цуцласан бичиг байв. [Mongolia Survey...1999 тал 50-51]

Дээрх баримтуудаас үзэхэд АНУ-ын тусламж дэмжлэгийг хүссэн тусламжийн бичгийг хууль зүйн үндэслэлтэй болгохын тулд Хиагтын гурван улсын гэрээ, Сюй Шү жаны хүчээр тулгаж, Автономийг устгасан бичгийн хуулбарыг дагалдуулан илгээсэн нь Богд Жибзундамба болон Жалханз хутагт нар Монголын тусгаар эрхийг устгасныг баримтжуулан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлж улс төрийн дэмжлэг олох гэсэн явдал байлаа.

Тэрхүү уулзалт болон Монголын улс төрийн байдлын талаар Эберхардт Засгийн газартаа Монголын талын бичиг захидал, хүсэлт сэлтийг уламжлан хүргүүлж, тайлагнасан зүйлийнхээ дотор ...Хятадын генерал Ху Шу Ченг [Сюй шү жан Л.Н] буюу "Бага Ху". Өргөө хотын монголчуудыг хэрхэн дарангуйлж буйг нүдээр харсан ажиглалтаа бичээд, энэ нөхцөл байдлыг эмгэнэлт явдал хэмээн нэрийдэж Ху-гийн эсрэг бослого гарна хэмээн өгүүлжээ. Мөн Япончууд энэ оронд идэвхитэй ажиллаж байгаа ба иргэний дайны улмаас цагаан Оросын хүч нь суларсаныг тэмдэглээд энэхүү хоосон орон зайг бөглөхийн тулд Америкийн төлөөлөгч илгээхийн чухлыг дурдсан байна.[Mongolia Survey...1999 тал 51]

Түүнчлэн "Монголчууд нь сүлд хийморь, тэмцэх чадвараа алдсан үндэстэн угсаатан огтхон ч биш юм. Ямар ч түрэмгийлэгчийн тийм /балмад/ үйлдэл харилцааны эсрэг тэд шууд зэвсэг барин тэмцэнэ", монгол нь "автономио сэргээн босгож, хадгалж хамгаалахын төлөө хэдэн жилийн өмнө Оростой үйлдсэний нэгэн адил аливаа бусад бүх улс үндэстэнтэй хоршиж хамсана. ...Гэхдээ тэрээр [Жалханз хутагт Л.Н] Америк юм уу Их Британи л шударга харилцана гэдэгт тийнхүү итгэн ивээлд нь орох хүсэлтээ тов тодорхой илэрхийлж байна. ...Монгол хэрэв зохих ёсоор зэвсэглэгддэг л юм бол ...тэрээр нижигнэн хөдөлж автономио сэргээн бататгахсан билээ"[A.J Campi, "Mongolia Studies" journal, 1992 тал 84-85] гэсэн өөрийн үзэлтээ дурдсан нь ихээхэн сонирхол татаж байгаа юм.

Үүнээс үзэхэд Жалханз хутагт Монгол улсын нэрийн өмнөөс төрийн тусгаар тогтнолыг сэргээх талаар АНУ-д гол итгэл найдвар тавьж, тэдний төлөөлөгчидтэй бүхий л арга замыг сүвэгчлэн харилцаж, дипломат харилцаа тогтоох дэмжүүлэх бодлого явуулж хэлэлцээр хийж, гэрээ байгуулахад маш нарийн тууштай ажиллаж байснаас нь үзэхэд бусад ямар ч улсын улс төрч нараас дутуугүй төрийн бодлоготой байсан нь тодорхой байна.

АНУ-ын консул түүний төлөөлөгчид Их хүрээнээс буцсаны дараа ...Монголын автономийг устгасантай холбогдуулан Дундад иргэн улсын Ерөнхийлөгчид баяр хүргэх төлөөлөгчдийг тэргүүлэн Бээжинд очих амаргүй хувь Дамдинбазарт дахин тохиожээ. Үнэн чанартаа энэ айлчлалын гол зорилго нь Да жунтаны амрыг эрж мэндчилгээ дамжуулах нэрийн дор Хятадын албаны хүмүүс болон гадаад улсын Америкийн төлөөний хүмүүстэй уулзан ..Монголын хуучин эрхийг олох арга сүвэгчлэх[Н.Магсаржав.УБ.,1994 тал 170] явдал байлаа.

Энэ үед Хятадад цэргийн бүлэглэлүүдийн хооронд засгийн эрхийн төлөө зөрчил тэмцэл хурцдан Японы талыг баримтлагч Дуань Цижүйн дэглэм засгийн эрхнээс огцорч Англи, Америкийн талыг барьсан Цао Күн тэргүүтэй Жилин бүлэг засгийн эрхийг авсан тул 1920 оны 7 дугаар сарын эхээр Сюй Шү жаныг Бээжингээс дуудан буцааж, баруун хойт хязгаарын сайдын тушаалаас чөлөөлжээ. Хятад дахь улс төрийн байдал тогтворгүй, Монголын өөртөө засах эрхийн асуудлаар чухам хэнд нь хандах вэ? гэдэг нь тодорхойгүй үед Монголын төлөөлөгчдийн дунд энэ талаар зарчмын шинжтэй үзэл бодлын зөрөлдөөн гарахын хамт Хятадын талыг дэмжигчид цөөнгүй байсан нь [Сюй Шү жан төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг өөрчилсөнтэй холбоотой.Л.Н] Жалханз хутагтын бодлого, үйл ажиллагаанд ихээхэн саад тотгор болж байв.

Бээжинд байх үедээ Жалханз хутагтыг Америкийн элчинтэй уулзаж амжсан, түүнд Ларсен хэлмэрчилсэн тухай Дилав хутагт намтартаа тэмдэглэсэн боловч чухам ямар асуудлаар хэлэлцсэн талаар өгүүлээгүй бөгөөд тэрхүү уулзалтын талаарх архивын баримт бичиг, мэдээ үгүй юм. Юун боловч Жалханз хутагт Америкийн төлөөлөгчидтэй өмнө нь уулзсан болоод тус улсад явуулсан тусламжийн бичгийн хариу ирсэн эсэхийг тандсан, цаг үеийн байдлыг танилцуулж, Монголын өөртөө засах эрхийг сэргээхэд туслах, Хятадын засгийн газарт нөлөөлөхийг хүсэмжилж, хоёр улсын цаашдын холбоо, харилцаагаа гүнзгийрүүлэхийг зорьсон нь мэдээжийн хэрэг юм.

Э.Ринчино хожим Жалханз хутагтын нийгэм улс төрийн үйл ажиллагааг үнэлж бичихдээ "1919-1920 онуудад Жалханз хутагтын үйл ажиллагаа идэвхижиж, өргөн цар хүрээтэй болсон юм. ...1920 онд Аньфуистуудын төгсгөлийн өдрүүдэд Жалханз хутагт Бээжинд хүрэлцэн очиж, Хятадын засгийн газарт хандан Монголын автономийг сэргээхийг хөөцөлдсөн боловч амжилт олоогүй. Бээжин дэх ...Нэгдсэн Улсын элчингээр дамжуулан Америктай дээрх асуудлаар хэлэлцээ хийж дэмжүүлэхийг

оролдсон боловч бас л бүтээгүй байна”[Элбек-Доржи Ринчино.Улан-Үдэ.,1998 стр 141-143] гэжээ.

Ийнхүү Богд Жибзундамба, Жалханз хутагт нарын Монголын тусгаар тогтнолын асуудлаар хэлэлцэж “Их улсад ашиг буй” хэмээн найр тавьж байсан авч ...Америк, Англи улс болбоос Монгол газар бага сага худалдаа нэвтрүүлэхийн төдийгөөс өөр харилцах ойртох явдалгүй бөгөөд Монголын төлөө Дундад улсын дотоод хэрэгт оролцож зохилдохгүй [Н.Магсаржав.УБ.,1994 тал 171] хэмээсэн байр суурийг баримталж байсан нь хоёр орны хоорондын цаашдын харилцаанд зохих тусгалаа олжээ .

Тухайн үед Жалханз хутагт Дамдинбазар Хятадын цэргийн эрхтнүүдийн хатуу хараа хяналт дор АНУ-ын элчин, консул төлөөлөгчидтэй удаа дараа нууцаар уулзаж, хоёр талын харилцан ашиг сонирхлын үүднээс Монголын тусгаар тогтнол, ард олны эрх чөлөөний төлөө тусламжийг эрж, итгэл өвөрлөсөн авч зохих үр дүнд хүрээгүй болно. Гэвч АНУ болон Монгол улсын улс төрийн харилцааны түүхэнд шинэ хуудас нээж өгсөн юм.

Эцэст нь өгүүлэхэд 1918-1920 оны Монгол-Америкийн улс төрийн харилцаанд холбогдох мэдээ баримтууд АНУ-ын Вашингтоны Үндэсний архивт хадгалагдаж буй аж. Тухайн үед Дундад Иргэн улсад сууж байсан АНУ-ын элчин сайд, Хаалганы консул төлөөлөгчид, Хятадын түшмэд, цэргийн эрхтнүүдтэй хувиараа болон албан ёсоор харилцаж байсан нийтдээ 50 боть архивын эх баримтууд хадгалагдаж буйг АНУ-ын монгол судлаач Campi.Alicia Jean цохон тэмдэглэсэн байдаг.

Иймд Монгол улсын Засгийн газар АНУ-ын Засгийн газартай архивын салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссыг байгуулан ажиллуулах үндсэн дээр Вашингтоны үндэсний архивт буй Монгол-Америкийн түүхэнд холбогдох архивын баримтын хуулбарыг шилжүүлэн авбаас XX зууны Монголын гадаад харилцааны түүхийн судалгааг гүнзгийрүүлэх, Богд Жибзундамба, Жалханз хутагт тэргүүтэй ихэс ноёдын төрийн тусгаар тогтнолын төлөө тэмцлийг шинжлэх ухааны үндэстэй бодитойгоор нээн харуулахад чухал ач холбогдолтой юм.

Abstract: The launching of economic and political relations between Mongolia and the United States occurred in the early 1920s thanks to enormous personal contribution of Damdinbazar the Djalkhanz Khutukt, a prominent clerical and political figure of the days.

His several missions to U.S. diplomatic liaison in China in 1919 and 1920 were aimed at securing the U.S. support for the newly declared Mongolian independence and an attempt to counter-balance the Chinese suzerainty.

Ном зүй

1. Ариун сэтгэл авралын үндэс. Дуртгал, намтар, өгүүлэл хэвлэлд бэлтгэсэн Л.Чойжилсүрэн. УБ., 2000
2. Ариунсайхан М. Гадаад монголын автономийг устгасан тухай асуудалд. ТС, Т-25, F-5. УБ., 1990
3. Богд Жибзундамба хутагтаас Монголын автономит эрхийг хэвээр үлдээхийг хүсч Дундад иргэн улсын Да жунтанд илгээсэн бичгийн хуулбар. [Үндэсний түүхийн музейн үзмэр]
4. Дэндэв Л. Монголын товч түүх. Дөтгөөр дэвтэр. УБ., 1934
5. Дилав хутагт Жамсранжав. Ар монголын улс төрийн дуртгал. УБ., 1991
6. Дүйнхэржав Г. Наян дөрвөн шидтэний нэг Дилова хутагт. УБ., 1991
7. Ишжамц Н. АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-Америкийн харилцаа [1900-1987]. УБ., 1999
8. Магсаржав Н. Монгол улсын шинэ түүх. УБ., 1994
9. Хоёр их хутагт. Эмхтгэсэн Г.Очирбат, Г.Лувсанцэрэн. УБ., 1994
10. Campi, Alicia Jean. 1988. The political relationship between the United States and Outer Mongolia. 1915-1927, The Kalgan Consular records. Doctoral dissertation, INDIANA UNIVERSITY.
11. Mongolia Survey A Publication of the Mongolia Society. Number six, 1999
12. A.J Campi, Perceptions of the outer Mongolia by the United States Governments as reflected in Kalgan/Inner Mongolia/ U.S Consular records 1920-1927 "Mongolia Studies" journal, vol, 14, 1992
13. Элбек-Доржи Ринчино о Монголии. Улан-Үдэ., 1998